ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/34/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261945 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор:В.Эрдэнэцогт Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Аудитор: М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1152
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
С.ЧИНЗОРИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 250,439.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Тайлант онд үүссэн 219,350.6 сая төгрөгийн авлага болон өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Чингис хаан банканд байрших 30,895.7 сая төгрөгийн сангийн мөнгөн хөрөнгө эрсдэлтэй хэвээр байгаа;

зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дугаар зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.2, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас 125 төрлийн өвчинд хэрэглэдэг 651 нэр

0001030839

төрлийн эмийг 30.0-70.0 хувийн хөнгөлөлттэй үнээр даатгуулагчийн хурууны хээгээр баталгаажуулан олгож эхэлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас тайлант онд 356.7 мянга гаруй иргэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрт төсвөөс 42,600.0 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Капитал банкнаас хүлээн авсан үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулж 3,652.5 сая төгрөгийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлж, зарцуулжээ.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт"-ийн 30.5 "Эрүүл мэндийн даатгал" хөтөлбөрт 2 хүрэх үр дүнг баталсан бөгөөд хэрэгжилтийг 96.4 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0425 SNAG-23.Docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**323,363,567.9**	**279,911,793.2**
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	170,365,956.4	161,057,086.6
33	АВЛАГА	106,206,748.2	80,227,268.8
34	УРЬДЧИЛГАА	1,646,539.8	994,251.4
35	БАРАА МАТЕРИАЛ	45,144,323.5	37,633,186.5
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**9,048,625.5**	**7,297,807.8**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**9,048,625.5**	**7,297,807.8**
39200	Биет хөрөнгө	3,309,095.0	3,003,936.3
39300	Биет бус хөрөнгө	5,739,530.5	4,293,871.5
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**332,412,193.4**	**287,209,601.0**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**60,591,940.2**	**218,321,666.5**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	**60,591,940.2**	**218,321,666.5**
41300	Өглөг	60,581,925.5	218,317,261.5
41400	Урьдчилж орсон орлого	10,014.8	4,405.0
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**271,820,253.2**	**68,887,934.5**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**271,820,253.2**	**68,887,934.5**
51100	Засгийн газрын оруулсан капитал	13,793.9	13,793.9
51200	**Хуримтлагдсан үр дүн**	**271,806,459.3**	**68,874,140.6**
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**332,412,193.4**	**287,209,601.0**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	1,528,709,517.1	1,584,963,351.6
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	163,708,631.7	228,117,403.9
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	163,708,631.7	228,117,403.9
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	6,203,676.7	2,298,800.8
120	Нийтлэг татварын бус орлого	2,629,463.0	2,298,800.8
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	1,358,797,208.7	1,354,547,146.9
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	1,583,292,030.8	1,787,867,530.8
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	1,583,292,030.8	1,787,867,530.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,602,781.6	12,452,605.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,452,404.0	6,197,982.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	580,155.1	816,464.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,987.3	167,094.0
2104	Хангамж, бараа материалын зардал	356,014.6	242,296.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,711.8	40,278.8
2107	Томилолт, зочны зардал	108,241.2	175,686.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,873,198.7	2,428,164.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,042,069.0	2,384,637.7
122	**Тусламжийн орлого**	3,574,213.7	0.0
212	**ТАТААС**	80,761,860.8	99,506,508.4
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	1,492,927,388.5	1,675,908,417.1
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	(54,582,513.8)	(202,904,179.1)
IV	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН**	37,021.4	0.0
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	51,592.5	53,331.0
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	(54,597,084.8)	(202,957,510.2)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**326,778,680.2**	**-**	**326,778,680.2**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(361,342.2)		(361,342.2)
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**326,417,338.0**	**-**	**326,417,338.0**
9	Тайлант үеийн үр дүн	(54,597,084.8)		(54,597,084.8)
10	**2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**271,820,253.2**	**-**	**271,820,253.2**
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25,191.5		25,191.5
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**271,845,444.7**	**-**	**271,845,444.7**
19	Тайлант үеийн үр дүн	(202,957,510.2)		(202,957,510.2)
20	**2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	**68,887,934.5**	**-**	**68,887,934.5**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**1,581,642,873.9**	**1,654,660,717.0**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	40,000,842.0	41,884,272.0
120	Нийтлэг татварын бус орлого	40,000,842.0	41,884,272.0
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**1,541,642,031.9**	**1,612,776,445.0**
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**1,816,119,712.8**	**1,674,134,100.8**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,816,119,712.8**	**1,674,134,100.8**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**51,025,964.4**	**50,582,798.3**
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,466,344.2	6,259,244.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	569,926.7	787,203.6

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,917.3	167,094.0
2104	Хангамж, бараа материалын зардал	213,301.1	213,240.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,736.5	42,653.8
2107	Томилолт, зочны зардал	111,395.4	175,686.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,902,377.5	2,399,574.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,550,965.6	40,538,100.8
212	**ТАТААС**	**92,362,381.6**	**89,976,040.8**
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**1,672,731,366.8**	**1,533,575,261.7**
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**(234,476,838.9)**	**(19,473,383.8)**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**17,374,538.6**	**121,308.6**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**17,374,538.6**	**121,308.6**
2200	Дотоод эх үүсвэрээр	17,374,538.6	121,308.6
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	**(17,374,538.6)**	**(121,308.6)**
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	**(251,851,377.5)**	**(19,594,692.4)**
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	422,217,333.9	170,365,956.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	170,365,956.4	161,057,086.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**1,518,474,614,500.00**	**1,597,998,224,844.24**	**(79,523,610,344.24)**	**105.2**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,603,474,614,500.00**	**1,602,800,750,438.74**	**673,864,061.26**	**100.0**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**50,266,661,900.00**	**50,031,062,354.02**	**235,599,545.98**	**99.5**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**6,326,515,200.00**	**6,189,761,342.00**	**136,753,858.00**	**97.8**
210101	Үндсэн цалин	3,901,511,400.00	3,218,014,185.65	683,497,214.35	82.5
210102	Нэмэгдэл	1,360,336,900.00	2,224,889,005.35	(864,552,105.35)	163.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	449,264,000.00	554,067,221.00	(104,803,221.00)	123.3
210104	Урамшуулал	615,402,900.00	192,790,930.00	422,611,970.00	31.3
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**800,985,400.00**	**781,848,915.04**	**19,136,484.96**	**97.6**
210201	Тэтгэврийн даатгал	544,522,900.00	532,997,749.08	11,525,150.92	97.9
210202	Тэтгэмжийн даатгал	64,137,300.00	62,715,136.90	1,422,163.10	97.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,351,300.00	50,172,369.52	1,178,930.48	97.7
210204	Ажилгүйдлийн даатгал	12,816,000.00	12,530,007.43	285,992.57	97.8
210205	Эрүүл мэндийн даатгал	128,157,900.00	123,433,652.11	4,724,247.89	96.3

2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**200,980,000.00**	**167,093,956.00**	**33,886,044.00**	**83.1**
210301	Гэрэл, цахилгаан	52,480,000.00	53,585,584.54	(1,105,584.54)	102.1
210302	Түлш, халаалт	45,000,000.00	38,399,078.78	6,600,921.22	85.3
210303	Цэвэр, бохир ус	25,000,000.00	20,293,991.46	4,706,008.54	81.2
210304	Байрны түрээс	78,500,000.00	54,815,301.22	23,684,698.78	69.8
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**236,706,400.00**	**227,118,556.44**	**9,587,843.56**	**95.9**
210401	Бичиг хэрэг	57,713,000.00	67,366,380.00	(9,653,380.00)	116.7
210402	Тээвэр, шатахуун	20,313,400.00	14,496,000.00	5,817,400.00	71.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	66,000,000.00	62,944,839.06	3,055,160.94	95.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,680,000.00	82,311,337.38	10,368,662.62	88.8
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**69,000,000.00**	**67,399,900.00**	**1,600,100.00**	**97.7**
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,000,000.00	27,399,900.00	1,600,100.00	94.5
210604	Урсгал засвар	40,000,000.00	40,000,000.00	-	100.0
2107	**Томилолт, зочны зардал**	**133,050,000.00**	**116,404,272.90**	**16,645,727.10**	**87.5**
210702	Дотоод албан томилолт	133,050,000.00	116,404,272.90	16,645,727.10	87.5
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**2,329,239,000.00**	**2,313,463,098.64**	**15,775,901.36**	**99.3**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	636,963,800.00	622,207,898.64	14,755,901.36	97.7
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	476,400.00	476,400.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,683,500,000.00	1,682,840,000.00	660,000.00	100.0
210807	Газрын төлбөр	938,800.00	938,800.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,360,000.00	3,000,000.00	360,000.00	89.3
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**40,170,185,900.00**	**40,167,972,313.00**	**2,213,587.00**	**100.0**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,109,020,900.00	40,109,020,900.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,165,000.00	58,951,413.00	2,213,587.00	96.4
212	**ТАТААС**	**89,982,467,000.00**	**89,976,040,813.00**	**6,426,187.00**	**100.0**
2122	**Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас**	**89,982,467,000.00**	**89,976,040,813.00**	**6,426,187.00**	**100.0**

212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	89,982,467,000.00	89,976,040,813.00	6,426,187.00	100.0
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**1,463,225,485,600.00**	**1,462,793,647,271.72**	**431,838,328.28**	**100.0**
2131	**Засгийн газрын урсгал шилжүүлэг**	**1,462,489,025,500.00**	**1,462,224,945,681.87**	**264,079,818.13**	**100.0**
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,462,489,025,500.00	1,462,224,945,681.87	264,079,818.13	100.0
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**736,460,100.00**	**568,701,589.85**	**167,758,510.15**	**77.2**
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	480,000,000.00	313,941,337.46	166,058,662.54	65.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	176,460,100.00	176,313,488.39	146,611.61	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,000,000.00	78,446,764.00	1,553,236.00	98.1
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ**	**(85,000,000,000.00)**	**(4,802,525,594.50)**	**(80,197,474,405.50)**	**5.7**
230001	Эргэж төлөгдөх зээл	(85,000,000,000.00)	(4,802,525,594.50)	(80,197,474,405.50)	5.7
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**1,518,474,614,500.00**	**1,591,834,994,103.53**	**(73,360,379,603.53)**	**104.8**
33	**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**1,603,474,614,500.00**	**1,596,637,519,698.03**	**6,837,094,801.97**	**99.6**
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,603,474,614,500.00	1,596,637,519,698.03	6,837,094,801.97	99.6
37	**БУСАД ЭХ ҮҮСВЭР**	**(85,000,000,000.00)**	**(4,802,525,594.50)**	**(80,197,474,405.50)**	**5.7**
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(85,000,000,000.00)	(4,802,525,594.50)	(80,197,474,405.50)	5.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	170,365,955,758.44	(170,365,955,758.44)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	161,057,086,571.16	(161,057,086,571.16)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	618.00	592.00	26.00	95.8
61	**БАЙГУУЛЛАГЫН ТОО**	**22.00**	**22.00**	**-**	**100.0**
62	**АЖИЛЛАГСАДЫН ТОО**	**298.00**	**285.00**	**13.00**	**95.6**
620001	Удирдах ажилтан	40.00	38.00	2.00	95.0
620002	Гүйцэтгэх ажилтан	258.00	247.00	11.00	95.7
65	**ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ**	**298.00**	**285.00**	**13.00**	**95.6**
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	260.00	260.00	-	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	8.00	-	8.00	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	29.00	25.00	4.00	86.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**		**21,143,641,232.73**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**		**21,143,641,232.73**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**		**647,849,423.47**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**		**69,482,782.00**
210101	Үндсэн цалин		7,518,306.00
210102	Нэмэгдэл		29,964,476.00
210105	Гэрээт ажлын хөлс		32,000,000.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**		**5,354,683.53**
210201	Тэтгэврийн даатгал		5,354,683.53
2104	**Хангамж, бараа материалын зардал**		**12,000,000.00**
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		12,000,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**		**15,000,000.00**
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
2107	**Томилолт, зочны зардал**		**59,282,400.00**
210702	Дотоод албан томилолт		59,282,400.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**		**114,276,857.94**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		53,984,167.20
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		60,292,690.74
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**		**372,452,700.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		273,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		99,352,700.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**		**20,495,791,809.26**
2131	**Засгийн газрын урсгал шилжүүлэг**		**20,000,000,000.00**
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		20,000,000,000.00
2133	**Олгосон санхүүжилт, шилжүүлэг**		**495,791,809.26**
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		495,791,809.26
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**		**21,143,641,232.73**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**		**21,143,641,232.73**
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		160,932,691.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		42,837,474.53
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		20,500,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		439,871,067.20

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 250,439.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 250,252.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 186.1 сая төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэгдсэн ба аудитаар тус 3 байгууллагыг түүвэрт хамруулсан.

3.1 Харьяа байгууллагууд

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 192.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 6.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 186.1 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөж хүргүүллээ.

Зөрчлийн нийт дүн 250,439.0 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 250,246.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 250,246.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлсэн.

Албан шаардлага

1. СБД-ийн ИХАШШ-ийн 2020 оны 181/ШШ2020/02421 дүгээр шийдвэрээр Чингис хаан банканд байрших ЭМДС-ийн харилцах дансны үлдэгдэл 27,861.2 сая төгрөгийг тус банкаар төлүүлэхээр шийдвэр гарсныг хангуулаагүй, 2023 оны байдлаар 30,895.7 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлд эрсдэл үүссэн хэвээр байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т “эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Чингис хаан банк дахь харилцах дансанд байршиж байгаа мөнгөн хөрөнгийг үлдэгдлийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэрийг хангуулах ажлыг эрчимжүүлэх, сангийн мөнгөн хөрөнгөнд учирсан эрсдэлийг бууруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Жилийн эцэст 892.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн. 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан "Энхтайван найрамдлын ордон"-ыг 2022 онд "М" ХХК-д түрээслүүлсэн 136.6 сая төгрөгийн түрээсийн төлбөрийн авлагыг барагдуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тооцоо нийлээгүй, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн. 20.2.5 -д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн авлагыг барагдуулах арга хэмжээ авах, найдваргүй авлага үүсэх эрсдэлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 218,321.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаагаас 87.6 хувь буюу 191,210.0 сая төгрөгийг улсын эрүүл мэндийн байгууллагуудын өглөг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны үлдэгдлээс 3.6 дахин нэмэгдсэн байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын сангаас төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад үүссэн өр төлбөрийг бууруулах, төсвийн зардлын удирдлагын сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Капитал банкны өр барагдуулахаар 2021-2022 онуудад хүлээж авсан нийт 46,680.7 сая төгрөгийн хөрөнгөнөөс 37,455.9 сая төгрөгийн хөрөнгө зарагдаагүй үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:
Капитал банкнаас өрөнд хүлээн авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах ажлыг нээлттэй, эрчимтэй зохион байгуулж, төсвийг хохиролгүй болгох.

Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

ЭМД-ын эрсдэлийн санг 40,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж байгуулахаар төлөвлөж нэг өдөр байршуулаад, буцаан зарцуулж байгаагаас үзэхэд эрсдэлийн сан болон төсвийг бодитой төлөвлөхгүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.2-т "эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах", 20 дугаар зүйлийн 20.2-т "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:
Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг бодитой төлөвлөж эрсдэлийн санг холбогдох журмын дагуу байгуулж, нэмэгдүүлэх тал дээр анхаарах.

Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулаагүй 192.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 186.1 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн, төсвийн ерөнхийлөн захирагчаас тавих дотоод хяналт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг 20.0 хувиар бууруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сан	7	250,246.5			4	250,246.5	3	-				
2	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	3	158.2			-	-	3	158.2				
3	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл	3	34.3			2	6.4	1	27.9				
Нийт дүн		**13**	**250,439.0**	**-**	**-**	**6**	**250,252.8**	**7**	**186.1**	**-**	**-**	**-**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	1	-					1	-				
	Дүн	**1**	**-**					**1**	**-**				